БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БӨА-2026/068/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2026 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: Б.Үүрийнтуяа<br>Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
4.1 Ерөнхий зүйл
4.2 Материаллаг байдал
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Х.БЕРИКБОЛ ТАНАА

2026.02.11 № 51
танай ____________-ны № ____________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2025 онд 5,064.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 4,993.4 сая төгрөг зарцуулж, 98.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

832605000055

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **351,111,958.13** | **141,673,668.98** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 275,005,125.95 | 61,108,603.37 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | - | - |
| 31140 | Касс арилжааны банк | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 275,005,125.95 | 61,108,603.37 |
| **3121** | **Төгрөг** | 275,005,125.95 | 61,108,603.37 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 275,005,125.95 | 61,108,603.37 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | - |
| **33** | **АВЛАГА** | 37,932,424.00 | 15,789,777.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 1,277,017.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | - |
| **335** | **Бусад авлага** | 37,932,424.00 | 14,512,760.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 37,932,424.00 | 14,512,760.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 38,174,408.18 | 64,775,288.61 |
| **351** | **Түүхий эд материал** | 35,848,408.18 | 44,223,208.71 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 35,848,408.18 | 44,223,208.71 |
| 35130 | Эм боох материал | - | - |
| **354** | **Хангамжийн материал** | 2,326,000.00 | 20,552,079.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,326,000.00 | 20,552,079.90 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,964,954,068.31** | **4,099,445,237.12** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,964,954,068.31 | 4,099,445,237.12 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,838,572,143.82 | 3,952,802,960.47 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,772,950,493.00 | 3,771,723,493.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (548,313,589.77) | (685,684,125.69) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 59,000,000.00 | 59,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - | (7,374,999.96) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 604,808,475.53 | 800,667,345.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (209,686,779.58) | (157,109,290.24) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 222,807,595.90 | 148,583,865.78 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (139,728,693.86) | (53,737,970.62) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 925,980.00 | - |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (925,980.00) | - |
| 39217 | Ном | 76,734,642.60 | 76,734,642.60 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **126,381,924.49** | **146,642,276.65** |
| 39301 | Програм хангамж | 4,555,389.00 | 4,555,389.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (3,133,464.51) | (3,573,112.35) |

| | | | |
|---|---|---|---|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 124,960,000.00 | 145,660,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,316,066,026.44** | **4,241,118,906.10** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **21,953,800.00** | **202,857,048.34** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 21,953,800.00 | 202,857,048.34 |
| **413** | **Өглөг** | 21,953,800.00 | 202,857,048.34 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 74.34 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | - |
| **4136** | **Бусад өглөг** | 21,953,800.00 | 202,856,974.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 21,953,800.00 | 202,856,974.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,294,112,226.44** | **4,038,261,857.76** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **4,294,112,226.44** | **4,038,261,857.76** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,270,268,493.00 | 3,290,968,493.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 3,270,268,493.00 | 3,290,968,493.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 347,617,289.93 | 75,606,721.25 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 347,617,289.93 | 352,157,089.93 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (276,550,368.68) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 676,226,443.51 | 671,686,643.51 |
| **52** | **Хяналтын бус хувь оролцоо** | **-** | **-** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,316,066,026.44** | **4,241,118,906.10** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,098,746,741.80** | **4,911,021,131.83** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **716,763,510.76** | **146,492,831.83** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 716,763,510.76 | 146,492,831.83 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | 26,055,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 16,323,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 9,731,900.00 |
| 120009 | Бусад орлого | 37,395,800.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 673,957,215.08 | 92,626,351.40 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 5,410,495.68 | 27,810,880.43 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,381,983,231.04** | **4,764,528,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 4,066,618,500.00 | 4,420,518,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,066,618,500.00 | 4,420,518,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,200,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,200,000.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **313,164,731.04** | **344,010,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 313,164,731.04 | 344,010,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,451,395,667.01** | **5,187,571,500.51** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,451,395,667.01** | **5,187,571,500.51** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,277,649,057.01** | **4,950,012,503.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,260,186,151.72 | 3,722,657,652.91 |
| 210101 | Үндсэн цалин | 2,213,018,235.07 | 2,519,558,841.91 |
| 210102 | Нэмэгдэл | 841,449,866.65 | 989,699,611.00 |
| 210104 | Урамшуулал | 205,718,050.00 | 213,399,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **416,876,500.00** | **460,375,761.58** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 283,476,100.00 | 316,584,623.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 33,350,100.00 | 37,249,969.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,675,000.00 | 19,194,589.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 16,675,000.00 | 17,469,315.69 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 66,700,300.00 | 69,877,264.08 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **312,766,481.04** | **339,893,477.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,842,284.88 | 36,794,353.00 |
| 210302 | Түлш, халаалт | 272,601,446.16 | 276,878,130.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 27,322,750.00 | 26,220,994.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 540,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 540,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **57,195,235.71** | **46,722,565.43** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 27,395,800.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 29,799,435.71 | 46,722,565.43 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **230,624,688.54** | **379,823,046.59** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,707,897.00 | 103,008,464.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 22,383,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 164,916,791.54 | 254,431,582.59 |
| **2111** | **Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр** | - | - |
| 211100 | Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр /ОН-УТ/ | - | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **173,746,610.00** | **237,558,997.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 173,746,530.00 | 236,269,474.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 128,002,500.00 | 204,379,674.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 45,744,030.00 | 31,889,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 173,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 173,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **80.00** | **1,116,523.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 80.00 | 1,116,523.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **647,351,074.79** | **(276,550,368.68)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | - |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө | - | - |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **647,351,074.79** | **(276,550,368.68)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **4,391,485,231.04** | **4,790,583,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,442,000.00** | **26,055,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,442,000.00 | 26,055,600.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 26,055,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 16,323,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 9,731,900.00 |
| 120009 | Бусад орлого | 5,442,000.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,386,043,231.04** | **4,764,528,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 4,066,618,500.00 | 4,420,518,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,066,618,500.00 | 4,420,518,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,260,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,200,000.00 | |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 4,060,000.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 313,164,731.04 | 344,010,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 313,164,731.04 | 344,010,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **4,294,020,151.71** | **4,918,835,122.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,294,020,151.71** | **4,918,835,122.58** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,114,835,671.71** | **4,691,699,999.58** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,232,004,908.72 | 3,726,659,316.15 |
| 210101 | Үндсэн цалин | 2,093,193,492.09 | 2,190,437,921.15 |
| 210102 | Нэмэгдэл | 917,631,698.00 | 1,302,174,296.00 |
| 210104 | Урамшуулал | 221,179,718.63 | 234,047,099.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **416,876,500.00** | **457,478,041.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 283,476,100.00 | 317,647,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 33,350,100.00 | 36,048,541.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,675,000.00 | 17,296,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 16,675,000.00 | 17,296,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 66,700,300.00 | 69,188,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **310,664,731.04** | **339,893,477.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,842,284.88 | 18,335,811.00 |
| 210302 | Түлш, халаалт | 272,601,446.16 | 295,336,672.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 25,221,000.00 | 26,220,994.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,814,920.00 | 3,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210604 | Урсгал засвар | 1,814,920.00 | 3,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **51,718,108.95** | **62,659,265.43** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,402,000.00 | 15,936,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 47,316,108.95 | 46,722,565.43 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 101,756,503.00 | 102,009,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 70,483,805.00 | 79,626,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 31,272,698.00 | 22,383,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **179,184,480.00** | **227,135,123.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 179,184,400.00 | 225,845,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 128,002,500.00 | 193,955,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 51,181,900.00 | 31,889,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 173,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 173,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 80.00 | 1,116,523.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 80.00 | 1,116,523.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **97,465,079.33** | **(128,251,222.58)** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **-** | **-** |
| 140001 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **100,655,000.00** | **85,645,300.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **100,655,000.00** | **85,645,300.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 100,655,000.00 | 85,645,300.00 |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 100,655,000.00 | 85,645,300.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(100,655,000.00)** | **(85,645,300.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **(3,189,920.67)** | **(213,896,522.58)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 278,195,046.62 | 275,005,125.95 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 275,005,125.95 | 61,108,603.37 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 3,270,268,493.00 | 676,226,443.51 | 347,617,289.93 | 4,294,112,226.44 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,270,268,493.00** | **676,226,443.51** | **347,617,289.93** | 4,294,112,226.44 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | - |
| C09 | Тайлант үеийн үр дүн | | | - | - |
| C10 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,270,268,493.00** | **676,226,443.51** | **347,617,289.93** | **4,294,112,226.44** |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,270,268,493.00** | **676,226,443.51** | **347,617,289.93** | **4,294,112,226.44** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 4,539,800.00 | 4,539,800.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,270,268,493.00** | **676,226,443.51** | **352,157,089.93** | **4,298,652,026.44** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | (4,539,800.00) | | (4,539,800.00) |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 20,700,000.00 | | | 20,700,000.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| D09 | Тайлант үеийн үр дүн | | | (276,550,368.68) | (276,550,368.68) |
| D10 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,290,968,493.00** | **671,686,643.51** | **75,606,721.25** | **4,038,261,857.76** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,064,758,500.00** | **4,993,363,899.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,064,758,500.00** | **4,993,363,899.58** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,826,216,500.00** | **4,767,518,299.58** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,742,130,000.00 | 3,726,659,316.15 |
| 210101 | Үндсэн цалин | 2,310,444,600.00 | 2,190,437,921.15 |
| 210102 | Нэмэгдэл | 1,198,677,100.00 | 1,302,174,296.00 |
| 210104 | Урамшуулал | 233,008,300.00 | 234,047,099.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 467,753,700.00 | 457,478,041.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 318,072,600.00 | 317,647,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 37,420,300.00 | 36,048,541.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 18,710,100.00 | 17,296,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,710,100.00 | 17,296,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 74,840,600.00 | 69,188,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 341,010,000.00 | 339,893,477.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,452,000.00 | 18,335,811.00 |
| 210302 | Түлш, халаалт | 295,337,000.00 | 295,336,672.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 26,221,000.00 | 26,220,994.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **81,355,500.00** | **63,229,265.43** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,323,700.00 | 15,936,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 65,031,800.00 | 47,292,565.43 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **190,967,300.00** | **177,258,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 168,584,300.00 | 154,875,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,383,000.00 | 22,383,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **238,542,000.00** | **225,845,600.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 238,542,000.00 | 225,845,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 206,652,200.00 | 193,955,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 31,889,800.00 | 31,889,800.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **5,064,758,500.00** | **4,789,467,377.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **4,420,518,300.00** | **4,420,518,300.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,420,518,300.00 | 4,420,518,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **344,010,000.00** | **342,893,477.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 344,010,000.00 | 342,893,477.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **300,230,200.00** | **26,055,600.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,323,700.00 | 16,323,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,731,900.00 | 9,731,900.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 274,174,600.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **265,005,125.95** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **61,108,603.37** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **134** | **135** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 99 | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 34 | 34 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 150.9 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 150.9 сая төгрөгийн алдааг залрууллаа. *Залруулсан алдаа:*

- Тайлант онд шинээр нэмэгдсэн 20.7 сая төгрөгийн газрыг ҮДТ-д үнэ төлбөргүй хөрөнгийн санхүүжилтээр тайлагнасан.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 19.4 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөөр зөрүүтэй тайлагнасан.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- ҮДТ-ийн цалингийн зардлыг 25.6 сая төгрөгөөр илүү, тогтмол зардлыг 18.5 сая төгрөгөөр, нийтлэг үйлчилгээний зардлыг 15.9 сая төгрөгөөр, үдийн хоолны зардлыг 36.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- МГТ, ҮДТ-нд төвлөрүүлэх шилжүүлгийг 3.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг 1.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийг 9.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар санхүүгийн асуудалтай холбоотой 0.5 сая төгрөгийн зөрчил[2] илэрч 1 акт тогтоон, 75.2 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Албан хаагчдад тайлант онд олгосон урьдчилгаанаас 2025 оны 4 дүгээр сард нэг албан хаагчид олгосон 500,000 төгрөгийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж тайлагнаагүй орхигдуулсан байна.
Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ",16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 26 дугаар зүйлийн 26.1-д "*Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө*",

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-д "*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*", 14.4.2-т "*14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага*", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Төлбөр барагдуулах акт тогтоов.*

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар 75.2 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал***

1.1.Илрүүлэлт:

Сургуулийн захирлын 2025.12.22-ны өдрийн А/42 дугаар тушаалаар байгуулагдсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг нь үндсэн хөрөнгийн тооллогыг хийж, тооллогын тайлангаар баримтжуулсан боловч санхүүгийн программын эд хөрөнгийн жагсаалтаар тооллого хийсэн /тооллогын тэмдэглэгээ, шилжүүлсэн, акталсан, дутсан зэрэг

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тэмдэглэгээгүй/, мөн жилийн эцсийн 64.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "*Нягтлан бодох бүртгэлийн зарчим*", 5.1 дэх хэсэг, "*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална*", 5.1.4-д "*үнэн зөв байх*", 12 дугаар зүйлийн 12.1-т "*Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна*", 12.2-т "*хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ*", 12.2.1-т "*жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө*", 13 дугаар зүйлийн 13.1-т "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.3 дугаар хэсгийн 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх", 14.3.2-т "журналд бичих", 14.3.3-д "дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

<u>1.2. Өгсөн зөвлөмж:</u>

Өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулж, аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах;

***2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал***

<u>2.1.Илрүүлэлт:</u>

Сургууль нь оны эцэст 202.9 сая төгрөгийн өглөгтэй гарч оны эхнээс 180.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд шинээр 189.9 сая төгрөгийн цахим кабинетын, 10.4 сая төгрөгийн үдийн хоолны, 2.5 сая төгрөгийг түрээсийн номын өглөгтэй гарсны 10.4 сая төгрөгийн үдийн хоолны өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

<u>2.2. Өгсөн зөвлөмж:</u>

Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөрийг хугацаанд барагдуулах, үлдэгдлийг баталгаажуулж ажиллах;

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй | 1 | 20,700.0 | | | 1 | 20,700.0 | 1 | 20,700.0 | | | | |
| Санхүүгийн ҮДТ, МГТ-гийн үзүүлэлтийг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 119,364.8 | | | 1 | 119,364.8 | 1 | 119,364.8 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 10,810.0 | | | 1 | 10,810.0 | 1 | 10,810.0 | | | | |
| **Дүн** | **3** | **150,874.8** | | | **3** | **150,874.8** | **3** | **150,874.8** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Урьдчилгаа цалинг дутуу суутгасан. | **1** | **500.0** | 1 | 500.0 | | | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн дүнг баталгаажуулаагүй, бараа материалын тооллого хийгээгүй дүнг баталгаажуулаагүй. | 1 | 64,775.4 | | | | | 1 | 64,775.4 | | | | |
| Тайлант онд 202.9 сая төгрөгийн өр үүсгэсэн 10.4 сая төгрөгийн өрийн тооцоо нийлж баталгаажуулаагүй. | 1 | 10,423.9 | | | | | 1 | 10,423.9 | | | | |
| **Дүн** | **3** | **75,699.2** | **1** | **500.0** | | | **2** | **75,199.2** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Санхүүжилтийн орлого дутуу мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй байна. | 1 | 273,778.7 | | | | | 1 | 273,778.7 |
| **Дүн** | **1** | **273,778.7** | | | | | **1** | **273,778.7** |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **273,778.7** | | | | | **1** | **273,778.7** |